

СИРИЙН ИРГЭНИЙ ДАЙН БА ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

ШУА-ын ОУХХ-гийн ЭША Ц. Алтангэрэл

Сири улсын тухай товч

Арабын Бүгд Найрамдах Сири Улс нь газар зүйн байрлал, геополитикийн хувьд ихээхэн анхаарал татсан бүс нутагт оршдог. Сирийн хүн ам нь шашин шүтлэгийн хувьд 74% Исламын шашны Сунна урсгалыг дагагч, 13% нь Шиа урсгалыг мөрдөгч, 10% нь Христийн шашинт, 3% Друз шашинтай. Харин угсаатны бүтцээр 90% нь Араб, үлдсэн 10%-ийн дийлэнх нь Курд юм. Тус улсын нийслэл нь Дамаск хот. 2013 оны байдлаар энэ улс 23,85 сая хүн амтай байсан бол өнөөдрийн байдлаар тэдгээрийн 4 сая гаруй нь /2015 оны албан ёсны мэдээгээр/ дүрвэж 6-8 сая хүн орон гэргүй болоод байна. Угсаатны хувьд 77-83%-ийг Араб, 7-8% Курд, Армян, Черкез болон бусад үндэстнүүдээс бүрдэнэ. Шашны хувьд исламын шашин голлох ба сунни урсгал 74%, Алеви 12%, Христын шашин 10% тус тус эзэлдэг. Мөн Еврей нарын жүүдийн шашны урсгалууд ч бий. Тус улс нь 1920-1946 оныг хүртэлх хугацаанд Францын захиргаанд байсан ба улмаар 1946 онд тусгаар тогтнолоо зарласан боловч, 1958 онд Египеттэй нэгдэн Арабын Нэгдсэн Бүгд Найрамдах улс болсон байна. Гэвч энэ нь улс удаан оршин тогтнож чадсангүй гурав жилийн дараа хоёр улс тус тусын улсыг дахин байгуулжээ. Энэ бүс нутаг нь эртний Асир, Вавилон, Перс, Грек Ром, Византи, Арабууд, Сельжук, Мамлюкүүд, Монголын эзэн гүрэн болон Төмөрийн улс хийгээд Оттоманы эзэнт гүрний мэдэлд оршиж шашин, улс төр, түүх, соёл иргэншлийн томоохон төв болж байв.

Сирийн иргэний дайнаас дүрвэгсдийн талаар

Сирийн иргэний дайны улмаас 4 сая гаруй хүн /НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын хийсэн 2015 оны 8-р сарын 29-ны албан ёсны мэдээллээр/ эх орноо орхин хил залгаа орнууд болох Турк, Ливан, Йордан, Ирак зэрэг оронд дүрвэн гарсан. Мөн мянга мянган хүн алс холын Кавказ, Персийн булан, Хойд Африк, Европ руу орогнол эрэн зугтаан гарсан юм. 2015 оны 2-р сарын байдлаар зөвхөн Турк улсад 2,1 сая Сирийн дүрвэгсэд орогнох болсон ба тэдгээрийн байрлуулах, хооллох, хувцас олгох зэрэг бүхий л зардалд 6 тэрбум ам.доллар зарцуулсан байна. 2011 оны 7-р сарын эхээр 15,000 Сири иргэд Турк улсын Яладаги, Рейханли, Алтиноозу дүүрэгт майханд орогнох болсон. 2011 оны 6-р сарын сүүлээр Ливан дахь Сири дүрвэгсдийн тоо 10,000-д хүрсэн. Мөн оны 12-р сар гэхэд нийт 1500 хүн Йорданд дүрвэн гарч орогнох газраа олсон байгаа явдал нь Сири улсад нүүрлэсэн иргэний дайнаас болж хичнээн сая хүн орох оронгүй оочих аягагүй болж толгой хорогдохоор харийн орныг зорин дүрвэж байгаа эмэгнэлт үйл явдал өрнөж байгааг дээр дурдсан тоо баримтаас мэдэж авч болно. Мөн дүрвэгсдийн их нүүдэл цааш улам газар авч Европ руу зад тавин цутган орж байгаа нь олон улсын хэмжээнд асар том асуудал үүсгэж байгаа билээ.

Сири улсад иргэний дайн үүссэн шалтгаан

Тунис, Египт, Ливид өрнөсөн “Аравын хавар” бослого нь Сирийн ард түмнийг Ассадийн дэглэмийн эсрэг тэмцэлд босох урам зоригийг сэргээсэн юм. Өнөөгийн Ерөнхийлөгч Башар Аль Ассад нь Сири улсыг 30 гаруй жил удирдан жолоодсон эцэг Хафез Аль Ассадийг залгамжлан 2000 онд Арабын Бүгд Найрамдах Сири улсын Ерөнхийлөгч болсон. Тэрээр “Арабын хавар” бослогыг эсэргүүцэгчдийг цэргийн хүчээр нугачин дарсан нь тус улсад иргэний дайны гал авалцахад хүргэсэн.

Сирийн иргэний дайны тухай товчхон

Сирийн иргэний дайн 2011 оны хавар “Арабын хавар” бослогыг эсэргүүцсэн үйл ажиллагаатай холбогдон гарчээ. Башар Аль Ассадын Засгийн газрын эсрэг сөрөг хүчин зэвсэглэн боссон. *Башар Аль Ассадын Засаг захиргаа иргэдийн тайван жагсаал цуглааныг цэргийн хүч ашиглан дарсан нь хямрал улам даамжрах шалтгаан болсон.* Сири улсад өрнөсөн иргэний дайны улмаас 140 мянган хүн амиа алдсан билээ. Тэдний ихэнх нь босогчдын гарт амиа алджээ. Иргэний дайны улмаас 0-10 насны 11 мянган хүүхэд амиа алджээ. Сирийн ард иргэд бүгд Башар Ассадын дарангуйллаас салж, өөрсдийнхөөрөө амьдрахыг хүсч байна. Сирийн хойд хэсэгт өрсөлдөгч хоёр армийн цэргүүд тулалдаж байна. Тэд Башар Аль Ассад гэсэн ганцхан дайсантай боловч одоо Аль Кайда бүлэглэлтэй холбоотой дайчид, босогчдын талынхан гэсэн хоёр хэсэгт хуваагдаж байлдах болсон юм. Нэг талд нь барууны орнуудын ар тал болсон цэргүүд байхад нөгөө хэсэг нь Лалын шашинт Ирак, Ойрхи Дорнодын Левант орнуудаас дэмжлэг авсан Сирийн босогчдын талын дайчдаас бүрдсэн жижиг бүлэглэл байгаа юм. Эцэг Ассадын үед гарч байсан бослогыг хайр найргүй нугачин дарсан нь өнөөдрийн иргэний дайны эх үүсэл гэж үзэж болох юм. Дөч гаруй жилийн тэртээ Сирид яг өнөөдрийнхтэй адил лалын хэт даврагсад эцэг Ассадын дэглэмийг эсэргүүцэн бослого дэгдээж зургаан жил байлдан тэмцэлдсэн. Тэр үед дэлхийн улс төрийн байдал өөр, ЗХУ ба АНУ гэсэн хоёр их гүрэн дэлхийг хуваан ноёрхлоо тогтоосон байлаа. Сирийн арми “Лалын ахан дүүс” нэртэй бүлэглэлийн гишүүд голлосон бослогыг нисдэг тэрэг, танк, онгоц, их буу ашиглан аймшигтай хэрцгийгээр дарж байхад дэлхий нийтээрээ дуугүй л өнгөрсөн. Учир нь Сири улс ЗХУ-ын нөлөөлөлд хүчтэй орсон байсан бөгөөд АНУ тэргүүтэй барууныхан босогчдыг зэр зэвсгээр дэмжих зэргээр тодорхой арга хэмжээ аваагүй юм. Хама хотыг Сирийн арми бүслэж байгаад хайр найргүй буудаж 20-40 мянган босогчдыг хядаж устгасан байна. Ийнхүү эцгийн туршлага хүүд нөлөөлж 2011 оны бослогыг нухчин дарна гэсэн санаа нь эсрэгээр эргэж 4 жил гаруй үргэлжилсэн иргэний дайны гал асаахад хүргэж ард түмнээ гал усны гашуун зовлонд нэрвэгдүүлээд сууж байна.

Бүгд Найрамдах Сири улсын ерөнхийлөгч Башар Аль Ассад

Сири улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Баат намын Ерөнхий нарийн бичгийн дарга Башар Аль Ассад нь 1965 оны 9-р сарын 11-нд төрсөн. Түүний эцэг Хазеф Аль Ассад 30 жил гаруй Сири улсыг удирдаж байсан бөгөөд түүнийг нас барсны дараа хүү Башар Аль Ассад 2000 онд Ерөнхийлөгчөөр

сонгогдсон. Тэрээр Сирийн ард түмэн түүний дэглэмийг эсэргүүцэн буруушааж, өөрчлөлт шинэчлэлийг авчрахыг шаардсан тайван жагсаал хийсэн боловч жагсагчдыг зэр зэвсгийн хүчээр нухчин дарахыг оролдож муйхар арга хэрэглэсэн нь иргэний дайн гаргахад хүргэсэн. Сирийн босогчид АНУ тэргүүтэй барууны орнуудын дэмжлэгтэйгээр Ерөнхийлөгч Башар Аль Ассадыг албан тушаалаасаа огцрон хөгжил дэвшлийн ардчилсан замыг сонгохыг шаардаж байгаа боловч тэрээр Оросын тусламж дэмжлэгт дулдуйдан сэнтийнээсээ зүгээр нэг мултрад уначих бодолгүй байгаа бөгөөд энэ тухайгаа ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдсэн байгаа. Хэзээ энэ эрхэм ард түмнийхээ эрх ашгийн төлөө суудлаасаа бууна тэр үед иргэний дайн эцэс болж түмэн олон түвшин амар амьдрах байх гэж бодож байна.

Эцэг Хазеф Аль Ассадын тухай товч

Хазеф Аль Ассад 1930 оны 10-р сарын 6-нд төрсөн бөгөөд 1971-2000 хооронд Сири улсын Ерөнхийлөгчөөр насан эцэс болох хүртлээ ажилласан. Тэрээр 1970-аас 1971 он хүртэл Ерөнхий сайдаар ажиллаж байсан ба 1971-ээс 2000 он хүртэл Баат намын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байлаа. 1963 оны төрийн эргэлтэнд идэвхтэй оролцож Агаарын зэвсэгт хүчний командлагчаар сонгогдсон. Засгийн эрх мэдлийг гартаа авангуутаа хувийн өмчийг дэмжих гадаад орнуудтай харилцаагаа сайжруулж бататгах бодлого барьж байлаа. Хүйтэн дайны үед ЗХУ-ын дэмжлэгтэйгээр Израилийн эсрэг тэмцэж байсан. Хазер Аль Ассад олон арван жил улс орноо удирдан жолоодож байсан тул түүний нөлөө нэр хүнд ихэд өссөн. Тэрээр биеийн байдал муудсан тул өөрийн залгамжлагчаа хайж эхэлсэн. Эхлээд дүү Рифаат Аль Ассадыг сонгох бодолтой байсан боловч Хазеф ахаа эмнэлэгт хэвтэх үеэр төрийн эргэлт хийх оролдлого хийсэн тэрээр харь оронд цөлөгдсөн. Дараа нь том хүү Бассел Аль Ассадыг залгамжлуулахаар сонгосон гэвч тэр 1994 онд автомашины осолд орж нас барсан. Эцэстээ сонголт Башар Аль Ассад дээр буусан байна. Тэр үед хүү Башарын улс төрийн туршлага дутмаг байлаа. Гэвч үүнээс өөр сонголт байхгүй байсан бөгөөд түүнийг насан эцэслэсэн 2000 онд үе залгамжлан Сири улсын Ерөнхийлөгчийн зөөлөн боловч “халгаатай” сэнтийд заларчээ.

Сири олон улсын анхаарлын төвд байна

Сири улсад өрнөж буй иргэний дайн, дүрвэгсдийн асуудал олон улсын түвшинд яригдаж шийдэхэд хүнд ярвигтай асуудал болж хувираад байна. Энэ дайны гол тоглогчид АНУ, ОХУ юм. Түүнчлэн 2013 оны 6-р сарын 17-19-ны хооронд Умард Ирландад болсон Их 8-ын дээд хэмжээний уулзалтын хэлэлцэх гол асуудал бол бүхэлдээ Сирийн тухай асуудал байлаа. Өөрөөр хэлбэл Сирийн асуудлаар олон улсын бага хурлыг хуралдуулж тэнд үүсээд байгаа дайны хурцадмал байдлыг энх тайванжуулах асуудлыг хэлэлцүүлэх талаар Америк, Оросын ерөнхийлөгчдийн байр суурь ямар байгаад дээд хэмжээний уулзалт гол анхаарлаа төвлөрүүлж байлаа. Юуны өмнө бүс нутагт удахгүй дэгдэж магадгүй болоод байгаа Ираны эсрэг байлдааны ажиллагааг эхлүүлэхэд нэгдмэл, хүчирхэг Сири улс Америк тэргүүтэй барууны орнуудад огт хэрэггүй. Лалын шашны шиа урсгалыг дагагчид олноор оршин суудаг, дээр нь Сирийн эрх баригчид хэзээнээсээ Америк, Барууны орнууд,

Израильд дургүй болохоор Ираны эсрэг дайн дэгдвэл хэний талыг баримтлах нь ойлгомжтой хэмээн цахим ертөнцөөр мэдээлсэн байгаа. Сири улс нь Оросоос олон жилийн турш зэр зэвсэг худалдан авсаар ирсэн, найрсаг харилцаатай, сайн түнш. Сирийн одоогийн Засгийн газрыг унагаад авбал Оросын зэвсгийн үйлдвэрлэлд нэлээд хүндхэн цохилт болно. Мөн Сири улс АНУ ба Барууны орнуудын нөлөөнд орох учраас ОХУ-ын ашиг сонирхолд огт нийцэхгүйгээс гадна тус бүс нутагт хяналт, нөлөөллөө алдах болно. Хятадын профессор Пан Зонингийн бичсэнээр “Сирийн хямрал нь зөвхөн тус улсын дотоодын асуудал төдий бус дэлхий дахиныг хамарсан асуудал болоод байна”. Тэрээр цааш нь: “АНУ Сири улсын дотоодын хэрэгт хөндлөнгөөс оролцон “дэлхийг зохицуулагч цагдаа” дүр исгэдэг бол Орос улс Сиритэй цэрэг, эдийн засгийн асар их харилцаа холбоотой төдийгүй нийгмийн харилцаанд ихээхэн ойр байдаг улс юм. Харин Хятад улс АНУ шиг “дэлхийг зохицуулагч цагдаа” дүр исгэдэггүй, Орос шиг ашиг сонирхол нөлөөлөл байхгүй” гэж бичсэн байна. Үнэндээ энэ хоёр улс НҮБ-ын хуралдаан дээр Америк тэргүүтэй барууны орнуудын бүх л саналыг үгүйсгэж, Ерөнхийлөгч Башар Асадыг зэр зэвсгээр дэмжиж байгаа юм. Орос, Хятад хоёр Башар Асадыг оронд нь гарч ирсэн хүн тухайн бүс нутагт явуулж буй өөрсдийнх нь бодлогыг дэмжинэ гэсэн магадлал бага болохоор дэмжээд байгаа. Ливийн хувьсгалын үеэр Каддафийг дэмжихгүй байсаар энэ улсыг нөлөөнөөсөө алдсан алдаагаа давтахыг хүсэхгүй байгаа.

Сирийн хямралтай холбоотой НҮБ-ын үйл ажиллагаа

Сири улсад өрнөж буй хямрал, иргэний дайнд нэг талаас Алавитын Засгийн газрын цэргүүд болон Шиита бүлэглэлийн дайчид, нөгөө талаас Сунни шашны босогч бүлэглэлүүд хоорондоо эрслэн тэмцэлдэж байгаа бөгөөд энэ дайнд нийт хагас сая орчим хүний амь үрэгдсэн байна гэж НҮБ-аас мэдээлжээ. Сирийн засгийн газар асар их аллага хядлага үйлдэж, хүний эрхийг зөрчиж байгааг НҮБ болон бусад олон улсын байгууллагууд буруушаасаар байна. Энэ хямрал сөргөлдөөний үед химийн зэвсэг олон удаа хэрэглэсэн мөн эсэргүүцэгчдийг шоронд хорьж тамлан, эрүү шүүлт тулгаж байна хэмээн буруутгаж байна.

**“Олон улсын харилцаа” сэтгүүлд хэвлүүлэхээр ирүүлэх
материалд тавигдах шаардлага**

1. Сэтгүүл нь **олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын эрх зүй, бүс нутаг, орон судлалын** чиглэлээр дотоод, гадаадын эрдэмтэд, судлаачдын үзэл бодол, санал шүүмж, **урьд өмнө хэвлэгдээгүй** судалгааны үр дүнг уншигч олонд хүргэх зорилготой.
2. Нийтлүүлэгчийн хэвлүүлэх материалын хэмжээ 5-20 хуудас (А4-ийн хэмжээтэй, мөр хоорондын зай 1,5; Times New Roman mon font-оор) байвал зохино.
3. **Бүтээлийг хэвлэсэн эх байдлаар эсвэл е-мэйлээр редакцийн зөвлөлд ирүүлнэ.**
 - Редакцид ирүүлсэн бүтээлийн эх дээр зохиогчид гарын үсгээ зурж баталгаажуулсан байна.
 - Зураг, график, схем, диаграмм зэрэг үзүүлбэр тус бүрийг нэг хуудсан дээр тод үзэмжтэй хэвлэсэн эхээр нь хавсаргана.
 - үзүүлбэр (зураг, диаграмм, график гм) бүрийг дангаар нь харахад агуулга нь ойлгогдохоор нэр, тайлбартай байх ёстой.
 - Ашигласан материалын жагсаалтыг багтаасан байна.
 - Бүтээлийг өөр хэлээр бичсэн бол англиар бичсэн абстактыг /ойролцоогоор 300 орчим үгтэй/ хавсаргана.
4. **Хэвлүүлэх бүтээлд тавигдах үндсэн шаардлага:**
 - a) **Бүтээлийн сэдвийг нийтэд нь том үсгээр бичнэ.** Сэдвийн доор зохиогчийн нэр, ажилладаг газрын хаяг бичигдэнэ. Олон зохиогчтой тохиолдолд нэр бүрийг тусгай тэмдэгээр ялгаварлан тэмдэглээд зохих тайлбар хийнэ.
 - b) **Дараа нь ажлын гол агуулга, үр дүнг тусгасан товчлол** (Abstract, Аннотация) оруулна. Товчлолыг бичлэгийн бусад хэсгээс ялгарах шрифтээр бичнэ.
 - c) **Товчлолын дор бүтээлийн гол санааг илэрхийлэх 5-аас доошгүй түлхүүр үг, эсвэл товч ойлголтыг оруулна.**
 - d) **Эрдэм шинжилгээний өгүүлэл дараах бүтэцтэй байвал зохино.** Үүнд:
 - a. Оршил
 - b. Судлагдсан байдал, судалгааны арга
 - c. Судалгааны үр дүн
 - d. Хэлцэмж (Discussion), санал дүгнэлт
 - e. Талархал
 - f. Ашигласан ном зохиол
 - g. Абстракт

Оршил: Судалгаа хийх болсон үндэслэл, шаардлага, тавьсан зорилгоо товч томъёолно.

Материал, судалгааны арга: Ажилдаа чухам ямар таамаглал дэвшүүлж, түүнээ батлахын тулд ямар сорил, туршилтыг ямар аргаар хэрхэн гүйцэтгэсэн; хичнээн хэмжээний материал, мэдээлэл хуримтлуулж, ямар аргаар боловсруулалт хийсэн тухай дурьдана.

Үр дүн: Энэ хэсэгт судлаач өөрийн гаргаж авсан үр дүнг баталгаатай, логик дэс дараалал сайтай, эмх цэгцтэй, ойлгомжтой бичнэ.

Хэлцэмж (Discussion): Өөрийн судалгааны үр дүнг бусад судлаачдын судалгааны үр дүн, онолын янз бүрийн чиглэл, үзэл баримтлалтай хэрхэн холбогдох хийгээд өөрийн таамаглалаа хэрхэн баталсан, эсвэл үгүйсгэсэн, ямар дүгнэлтэнд хүрч байгаа зэргийг ишлэл, баримт, баталгаа нотолгоотой гаргана.

Талархал: Эрдэм шинжилгээний ажил ямагт хамтын бүтээл байдаг. Энэ ажлын санааг олох, хэрэгжүүлэх, үр дүнг боловсруулах, шаардлагатай нэмэлт мэдээлэл авах, биечлэн санал солилцох зэргээр хамтран ажиллаж туслалцаа үзүүлсэн эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, тухайн ажлыг санхүүжүүлсэн байгууллага, хүмүүст хандаж талархал илэрхийлж болно.

Ишлэл хийх ба ашигласан бүтээлийн жагсаалт: Ишлэл авах олон арга бий боловч зохиогчийн нэр, бүтээл хэвлэгдсэн оныг бичдэг журмыг дэлхий дахинаа илүүтэй хэрэглэдэг. /Чикаго эсвэл APA/

Ишлэл авахад дараах журам баримтална. үүнд:

- a) Нэг бүтээлийг нэр заан ишлэл авахдаа бичлэгийн хэлбэрээс хамааран Fagon & Young
 - a. (1978), аль эсвэл (Murton 1963) гэх,
- b) Олон бүтээлээс нэгэн зэрэг ишлэл хийхдээ хугацааны дарааллыг баримтлах ба нэг зохиогчийн нэг онд гарсан хэд хэдэн бүтээлийг үсгээр ялгана. Ж: Zahavi 1972; Halliday 1978; Arnold 1981a, b гм,
- c) Гурваас дээш зохиогч бүхий бүтээлээс ишлэл авахдаа эхний зохиогчийн нэрийн ард # et al., ... и др., ... нар гм гэж товчлоод оныг бичих,
- d) Давхар ишлэл авсан бол хаалтанд хэний, ямар бүтээлээс дамжуулан авснаа заавал бичнэ.

Ишлэл авсан ном зохиолын жагсаалт хийхдээ дараах нийтлэг журмыг баримтална.

Нийгэм, хүмүүнлэгийн салбарт хуудас бүрийн доор зүүлт хийсэн байлаа ч гэсэн бүтээлийн эцэст ашигласан бүтээлийн жагсаалтыг бүрэн бүтнээр оруулна.

a) Эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлээс ишлэл хийхэд:

- 1) Викторов Г.А., 1970. Межвидовая конкуренция и сосуществование

экологических гомологов у паразитических перепончатокрылых. Ж. Общ. Биол. 31(2): 247-255.

- 2) **Zelmer, D. A. & Esch, G. W.** 1999. Robuts estimation of parasite component community richness. *Journal of Parasitology*, **85**: 592-594.

b) Ном, эмхэтгэлээс ишлэл хийхэд:

1. Вольф Г.Н., 1970. Дисперсия оптического вращения и круговой дихроизм в органической химии. / Ред. Снатцке Г.М.: Мир. С. 348-350.
2. Илиел Э., 1965. Стереохимия соединений углерода. Пер. с англ. М.: Мир. 210 с.
3. Emlen, S. T. 1978. The evolution of cooperative behaviour in birds. In: *Behavioural Ecology* (Ed. By J. R. Krebs & N. B. Davies), pp. 245-281. Oxford: Blackwell Scientific.

c) Диссертациас ишлэл хийхэд:

1. Шефтель Б.И., 1985. Экологические аспекты пространственно-временных межвидовых взаимоотношений землероек Средней Сибири. Автореф. Дис. ... канд. биол. наук. М.:ИЭМЭЖ АН СССР. 23 с.
2. Smith, J. K. 1985. Investigations on the freshwater crab. Ph.D. thesis, University of Durham.

